



“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ

1. ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМ, АРДЫН ХУВЬСГАЛЫН 93 ЖИЛИЙН ОЙГ “ХҮЙ ДОЛООН ХУДАГ”-Т ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН
2. 2015 ОНЫ ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМ, АРДЫН ХУВЬСГАЛЫН 94 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
3. ХҮЙ ДОЛООН ХУДАГТ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЯР, НААДАМ /2015 он/
4. “ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ II” АЯЛАЛ, АМРАЛТ, ЗУГААЛГЫН ХӨТӨЛБӨР

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМ, АРДЫН ХУВЬСГАЛЫН 93 ЖИЛИЙН ОЙГ “ХҮЙ ДОЛООН ХУДАГ”-Т ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2014 оны 7 дугаар сар 16

ХАРЬАЛАГДАХ САЛБАР ХОРОО: ТОХИЖИЛТ, ЗАСВАР, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ХОРОО

ТАЙЛАН БИЧСЭН: “МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ

“Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ нь Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2223 жил, Их Монгол улсын 808 жил, Ардын хувьсгалын 93 жилийн ойг “Хүй долоон худаг”-т тэмдэглэн өнгөрүүлэх талаар 40 зүйлийн ажлууд төлөвлөн “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ийн дарга П.Цогтбаатар зохион байгуулж тус байгууллагын нийт 30 ажилтан “Хүй долоон худаг”-т гаргасан төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд амжилттай хийж гүйцэтгэлээ.

Баяр наадмын зохион байгуулах хорооны салбар хороо болох Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-т 105.900.000 төгрөг хуваарилан төсөвлөгдсөнөөс 37.200.000 төгрөгийн нэмэлт төсөв оруулан нийт 143.100.000 төгрөгийн төсөвтэй хийж гүйцэтгэлээ. “МНЦ” ОНӨТҮГ-т Улсын их баяр наадмыг зохион байгуулах хорооны Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооноос хуваарилсан төсөвт ажлууд:

1. Тохижилтын ажил
2. Цэцэрлэгжүүлэлт, зүлэгжүүлэлтийн ажил
3. 40 тн-ын контейнерэн 00-ыг засварлах
4. Морь барианы газрын хог хаягдлыг цэвэрлэх, ачиж зайлуулах
5. Эндсэн мал болон бохир усны нүх ухах
6. Нийтийн бие засах газрын бохир соруулах, цэвэр ус хангах
7. Машин механизм
8. Сэтгүүлч, үзэгчдийн индрийг шинээр хийх
9. Зүлэгжүүлэлт, морь барианы хэсгийн усалгаа

1. Цэцэрлэгжүүлэлт, тохижилт, усалгаа, контейнерэн 00-ын талаар

Хүй долоон худгийн нийтийн эзэмшлийн хуваарьт зам талбайд усалгаа, цэвэрлэгээ, цэцэрлэгжүүлэлт, хог тээврийн үйлчилгээ, хогийн сав байрлуулах, контейнерэн “00” ажиллуулах ажилд нийт 159 хүн, 17 машин, техник гарч ажиллаа.

- Нийт 1350м² талбайд 46.000 ширхэг нэг наст цэцэгжүүлэх ажлыг Хүй долоон худаг руу ордог авто замын аюулгүйн тойргийн эргэн тойронд болон үйлчилгээний А талбайн голд 3 давхар өндөрлөгтэй хийхэд 6-р сарын 05-аас 7-

р сарын 13-ны хооронд 2 машин буюу 12 хүн ажилласан бөгөөд орчин тойрны 920 м2 талбайд нөхөн зүлэгжүүлэлт хийн, тус цэцэгжүүлэлт, зүлэгжүүлэлтийн усалгааг тогтмол хийж байсан. **/хавсралт зураг №1/**

- Үйлчилгээний талбайн тохижилтод 50 ширхэг түшлэгтэй амралтын сандал, 150 дугуйт хогийн сав, 80 ширхэг суурин хогийн сав, 31 байршилд бие засах газруудыг байрлуулан наадамчин олонд үйлчиллээ.
- Шинээр хийсэн бүтээн байгуулалтын хувьд 800 метр урттай, 2,5 метрийн өргөнтэй бетон явган хүний зам **/хавсралт зураг №2/**, “А, Б” замын голд асфальт, бетон болон эко хавтангаар 500 автомашины зогсоолын ажлыг хийж гүйцэтгэв. **/хавсралт зураг №3/**
- Хүй долоон худгийн хурдан морь барианы газар түүний эргэн тойронд 2 машин 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийт 39 рэйсээр 240 тн усаар тогтмол усалгаа хийсэн. Усалгааг СБД-ийн ТҮК хийж гүйцэтгэв.
- СХД болон Улаанбаатар нэгтгэлээс 7 машин хог тээвэрт ажиллаж өдөрт 64 хүн 5 удаагийн давтамжтайгаар нийт рэйс буюу 374 тн хог ачиж тээвэрлэсэн. 7-р сарын 13-ны оройны байдлаар Хүй долоо худаг орчмын хог цэвэрлэгээний байдал 60 хувийн гүйцэтгэлтэй байснаас 7-р сарын 14-ны өдөр СХД-ийн ТҮК-ийн 30 ажилтан, “Монгол Наадам Цогцолбор”-ын оффисийн ажилчид болон, тохижилт, үйлчилгээний хэлтсийн ажилчид нийлэн хог цэвэрлэгээг хийж дуусгасан.
- 7 дугаар сарын 10 аас 13-ны өдрийг дуустал хурдан морины барианы газар нийтийн бие засах 31 ширхэг контейнерэн “00” –ын 6-8 тн-ын багтаамжтай цэвэр усны ёмкость ус зөөвөрлөх, бохир ус соруулах ажлуудыг “Голден Эко” ХХК хийж гүйцэтгэсэн. Тус компани нь нийт 5 ширхэг цэвэр усны машин, 8 ширхэг бохирын машинтайгаар Хүй долоон худагт ажиллаж 2292 тн бохир ус соруулж, 1705 тн цэвэр ус зөөсөн.
- 31 ширхэг контейнерэн “00”-ын хувьд Ерөнхийлөгчийн хотхонд 1 ширхэг, Баяр наадмын комисст 2 ширхэг, Цагдаа толгой дээр 2 ширхэг, “Монгол Наадам Цогцолбор”-ын оффист 1 ширхэг, үйлчилгээний А, Б талбайд 25 ширхэг “00” тус тус ажиллалаа. 1 ширхэг контейнерэн “00”-ын мотор шатаж ус шахах боломжгүй болсныг газар дээр нь арга хэмжээ авч, үйл ажиллагааг зогсоолгүйгээр гар аргаар ажиллуулсан.

2. Эндсэн мал болон бохир усны нүх ухах талаар

Хүй долоон худагт 4*4-ийн хэмжээтэй 3 метрийн гүнтэй эндсэн малын нүх 1 ширхгийг, 3*3 хэмжээтэй 2,5 метрийн гүнтэй бохир усны нүхийг үйлчилгээний А,Б зогсоолын талбайд 1 ширхэг, үйлчилгээний А талбайд 1 ширхгийг тус тус ухаж бэлтгэсэн бөгөөд тус нүхэнд хүнсний үйлчилгээ эрхлэгчид бохир усаа хийсэн. 3 ширхэг хурдны морь эндсэнийг зориулалтын нүхэнд булж дарав.

3. Морь барианы газар индэр шинээр барих, үзэгчдийн сандал байршуулах талаар

Хүй долоон худгийн морь барианы газарт хийгдэх тохижилт, засвар, үйлчилгээний зардалд тусгагдсаны дагуу 2.5*4 хэмжээтэй сэтгүүлчийн индэр 1 ширхгийг **/хавсралт зураг №4/**, 4*18 хэмжээтэй 200 хүний багтаамжтай 2 давхар үзэгчдийн индэр 1 ширхгийг **/хавсралт зураг №5/** тус тус шинээр бариулан 7-р сарын 10-ны өдөр эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авлаа. Тус индрийг барилга, угсралтын “Түмэн төмөрт” компани захиалгаар хийж гүйцэтгэлээ. Мөн морь барианы газарт 3000 үзэгчдийн зөөврийн суудал, 120 хүний суурин суудал байрлуулан тус суудлууд дээр давхардсан тоогоор 52.000 орчим үзэгч сууж /Хүй долоон худагт ойролцоогоор нийт 100,000 гаруй хүн цугларсан/ хурдан морины уралдааныг үзэж сонирхсон. **/хавсралт зураг №6/** Дээрх тоог уралдааны насаар ангилбал:

1. Хязаалан – 4000 орчим /07.10-ны өглөө/
2. Шүдлэн – 4500 орчим /07.10-ны өдөр/
3. Азарга – 4500 орчим /07.11-ний өглөө/
4. Их нас – 6000 орчим /07.11-ний өдөр/
5. Соёолон – 10 000 орчим /07.12-ны өглөө/
6. Даага – 8000 орчим /07.12-ны өдөр/

7. Эрлийн морьдын дээд нас – 4000 гаран /07.13-ны өглөө/
8. Эрлийн морьдын дунд нас – 4500 орчим /07.13-ны өдөр/
9. Эрлийн морьдын доод нас – 4500 орчим /07.13-ны үдээс хойш/

Үзэгчдийн 3000 суудлаас 7-р сарын 12-ны орой 600 суудлыг манай байгууллагын Тохижилт, үйлчилгээний хэлтсийн ажилчид Б талбай буюу Урлагийн талбай дээр Уяачдын баярт зориулан угсран байрлуулж “Уяачдын наадам”-ыг наадамчин олон тухлан сууж үзэх боломжоор хангасан. Уяачдын наадмын үзэгчдийн тоон үзүүлэлтийг харахад суудлын тоо багадсан байсан бөгөөд наадам үзэхээр ирсэн үзэгчдийн талаас илүү хувь нь газар суун мөн суудлын тоо хэтрүүлэн авирч, суудал хуваан сууж байсан.

4. Худалдаа, үйлчилгээний талаар

Худалдаа, үйлчилгээний “Б” талбай дээр хөдөлгөөнт тоглоомын 43, гэрэл зураг 5, унадаг дугуй түрээсийн 2, кино үзвэрийн 2, бэлэг дурсгал, тоглоомын худалдааны 21, амьтны хүрээлэн, 6 D кино театр зэрэг сонирхолтой цэгүүдээр наадамчин олондоо үйлчиллээ. **/хавсралт зураг №7/**

5. Нийтийн тээврийн үйлчилгээний талаар

“Хүй долоон худаг”-руу Railbus буюу төмөр замын автобусыг явуулахаар болсонтой холбогдуулан Давааны өртөө зогсоолоос наадмын талбай хүрэх 2 км орчим зайд хайрган түр зам тавьсан. Энэхүү замаар Нийслэлийн тээврийн газраас том оврын автобус иргэдэд үйлчилсэн. Мөн 5 ширхэг J-800EV загварын цахилгаан автомашинаар Хүй долоон худгийн автобусны төв зогсоолоос А,Б зогсоол хүртэл шинээр тавигдсан 2,7 км 800 метрийн урттай 4 метр өргөн замаар өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүдэд үйлчилсэн. **/хавсралт зураг №9/**

Мөн НЗДТГ-аас 2 ширхэг Mitsubishi маркийн цахилгаан машиныг туршилтын журмаар явуулж иргэдэд үйлчилсэн. **/хавсралт зураг №10/**

ДҮГНЭЛТ

Улсын их баяр наадам, Ардын хувьсгалын 93 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд манай “Монгол Наадам Цогцолбор”-ын төлөвлөгөөт ажлууд бүрэн хийгдэж, ялангуяа тохижилт, үйлчилгээ эмх цэгцтэй, шороо тоосгүй байж, олон нийтийг наадуулах, зугаацуулах үйл ажиллагааг тодорхой хэмжээнд хийж наадамчин олны ая тухтай наадах боломжийг хангаж, амжилттай сайн зохион байгуулж өнгөрүүлээ гэж дүгнэж байна.

Цаашид анхаарч ажиллах арга хэмжээний талаарх санал

- Хүй долоон худаг орчмын хог цэвэрлэгээний зардлыг нэмэгдүүлэх, ТҮК-ийн ажилчдын тоог нэмэгдүүлэх
- Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн цахилгаанаар хангах ажил цагийг нь тулгаж эхэлснээр контейнерэн “00”-ын ажиллагааг 100 хувь шалгаж чадалгүй ажиллуулсан. Үүнээс үүдэн 7-р сарын 10-ны өдөр контейнерэн “00”-ууд доголдолтой ажилласан. Тус компанийн ажилчдын тоо цөөдсөнөөс худалдаа, үйлчилгээ, хүнсний зөвшөөрөлтэй иргэд цахилгаанаа татуулах гэж цаг алдсан, үүнээс үүдэн 1 өдрийн орлого алдсан, хураамж, татвар өндөр авч байгаа талаарх санал, гомдол тасраагүй. 7-р сарын 13-ны орой хариуцсан ажилчид нь хуваарилагдсан талбай дээрээ байгаагүйгээс үүдэн худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэд цахилгааны утсаа салгах гэж цахилгаан хуваарилах самбарын хаалгыг эвдэж байсан.
- Үйлчилгээний болон урлагийн талбайд морьтой хүмүүс нэвтрэхгүй байх зорилгоор хамгаалалт болон морины уяа, зэл хийх.
- Хүнсний үйлчилгээ буюу хуушуурын зөвшөөрлийн тоог багасгах.
- Үйлчилгээний болон урлагийн талбайд сонсогдохуйц зарлалын радио узель тавих. Үүгээр хурдан морины уралдааны цаг болон, Хүй долоон худагт зохиогдож буй арга хэмжээнүүдийг зарлах, байршлыг зааж өгөх.

- Хүй долоон худаг орчмын зохион байгуулалт, үйлчилгээний байршлыг харуулсан схем бүхий самбар, хог хаяхыг хориглосон тэмдэглэгээ бүхий самбар, наадмын хөтөлбөр, хурдан морины уралдааны цагийн хуваарь зэргийг харуулсан самбаруудыг байршуулах.
- Үйлчилгээний болон урлагийн талбай 2-ын дундах цахилгаан автобусны зам болон явган хүний зам, уулын энгэрээр хогийн савнуудыг нэмэгдүүлэн байршуулах.
- Үзэгчдийн 3000 сандлын ард талд цагдаагийн өндөржүүлсэн хамгаалалт нэмэлтээр гаргах. Хүй долоон худгийн тохижилт, зохион байгуулалтаас үүдэн жилд ирж хурдан морины уралдаан үзэх үзэгчдийн тоо тооцоолсон байдлаас нэмэгдэж байгаа учир үзэгчдийн сандлын арын аравчнаас авиран гарах, морио уях зэргээр сандал нураах нөхцөлийг бүрдүүлж байна.
- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг нийтийн тээврийн автобусны зогсоолоос А, Б зогсоол хүртэлх зайд зөөх зориулалт бүхий цахилгаан автобусны тоог 20 хүртэл нэмэгдүүлэх.

ХАВСРАЛТ ЗУРГУУД



Хавсралт зураг № 1



Хавсралт зураг № 2



Хавсралт зураг № 3



Хавсралт зураг № 4



Хавсралт зураг № 5



Хавсралт зураг № 6



Хавсралт зураг № 7



Хавсралт зураг № 8



Хавсралт зураг № 9



Хавсралт зураг № 10

ХҮЙ ДОЛООН ХУДАГТ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЯР, НААДАМ /2015 он/

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА	ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА	ТАЙЛБАР /Үйлчилгээний нэр төрөл/
1	"ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ" хөтөлбөрийн зуны арга хэмжээ зохион байгуулалт /дугуй, морь, сур харваа/	V/16 - IX/19	НЗДТГ, БТСГ, ММСУХ, МҮСХ, МДХ	<u>Нээлт, хаалт</u> <u>Хоол үйлчилгээний талбай</u> ✓ Талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ✓ Сандал -30ш, ✓ Хогийн сав-30ш, ✓ Бие засах газар-2ш /Цахилгаанчин-1, сантехникч- 1, Талбайн цэвэрлэгээ- 5 хүн, тогооч-1, манаач-1/ <u>Бусад үеэр</u> ✓ Талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ✓ Сандал -12ш, ✓ Хогийн сав-12ш, ✓ Бие засах газар-1ш /Цахилгаанчин, сантехникч дуудлагаар, цэвэрлэгээ-3, тогооч-1, манаач-1/
2	МОНГОЛ ЦЭРГИЙН ЖАВХАА	V/23	НЗДТГ	✓ Сандал 2000ш
3	Хүүхдийн баяр	V/30 - VI/01	НСУГ, МХО	Цуцлагдсан.
4	"ТАЛЫН САЛХИ 2015" мото спортын фестиваль	VI/06	НЗДТГ, МЧАДХолбоо ТББ	<u>Автобусны зогсоол</u> ✓ Талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, ✓ Бие засах газар-2ш /Цахилгаанчин-1, сантехникч- 1, цэвэрлэгээ -5 хүн, тогооч-1, манаач-1/
5	ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМ	VII/10-13	ҮИБН зохион байгуулах коммис	<u>Соёл, урлагийн талбай</u> ✓ Сандал -16ш ✓ Хогийн сав-20ш ✓ Талбайн цэвэрлэгээ-3 хүн ✓ Цахилгаанчин-1 хүн

“Монгол Наадам Цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар

				<u>Морь барианы газар</u> ✓ Хогийн сав-14ш ✓ Талбайн цэвэрлэгээ- 2 хүн <u>Хоол үйлчилгээний талбай</u> ✓ Сандал - ✓ Хогийн сав- ✓ Цахилгаанчин- ✓ Талбайн цэвэрлэгээ- <u>Бие засах газар</u>
6	АДУУЧИН-2015 улсын уран уургач бугуйлчдын тэмцээн	VII/14	МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор	Тухай бүрт нь төлөвлөгөө өгнө.
7	БГД-ИЙН 50 ЖИЛ	VII /18,19	БГД	✓ Эко автобус- 15ш ✓ Цахилгаан эрчим хүч- 2 өдөр ✓ Цагаан хоолой- 1 ком ✓ Тайз, хөгжим- 1 ком ✓ Гэр- 13ш /их гэр, жижиг гэр/ ✓ Асар- 22ш /Монгол, цагаан/ ✓ Талбайн усалгаа- 3 рейс ✓ Хогны машин- 3 рейс ✓ Угсардаг сандал- 3000ш ✓ Гудамжны сандал- 30ш ✓ Асарын сандал- 36ш ✓ Асарын ширээ- 6ш ✓ Гудамжны сандал- 30ш ✓ Хогийн сав- 80ш ✓ Бүх ажилчид
8	Хүй долоо "SUMMER NIGHT" шоу тоглолт	IX/5,6	СУГ, НАЖГ	Тухай бүрт нь төлөвлөгөө өгнө.
9	ХҮРЭЭ ЦАМ, ДАНШИГ НААДАМ /Айрагны баяр/	VIII/08	НЗДТГ, СУГ, МБШТГХ	
10	“УБЦТС” ХК баяр	VIII/15	УБЦТС ХК	
11	ШИЛМЭЛ МАЛ ҮЗЭСГЭЛЭН- 2015	IX/12,13	ХХААЯ, НГТХААГ	



“ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ II” АЯЛАЛ, АМРАЛТ, ЗУГААЛГЫН ХӨТӨЛБӨР

Хаана: Хүй долоон худагт

Хэзээ: 2015 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 13:00 цагаас

Санаачлан зохион байгуулагч: “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ



Дэмжигч байгууллага: “Мон- Алтон” ХХК



Хамтран зохион байгуулагч холбоо, клуб, дэлгүүрүүд:





МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОРЫН “ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР ГАДААД, ДОТООДЫН ИРГЭД ЖУУЛЧДАД ҮЙЛЧЛЭХ БОЛОМЖТОЙ

Хөтөлбөрийн танилцуулга:

Манай байгууллага Хүй долоон худгийн тохижилт, бүтээн байгуулалтын үйл явцыг олон нийтэд сурталчилах, Найрсаг Улаанбаатар төслийг дэмжин ажиллах үүднээс “ЭРҮҮЛ ИРГЭН- ЭКО ХӨГЖИЛ” Аялал, амралт, зугаалгын хөтөлбөрөө 2 дахь жилдээ зохион байгууллаа. Нээлтийн үеэр НЗДТГ-ын ажилчид, Монголын дугуйн холбоо, Монголын хөнгөн атлетикийн холбооны тамирчид, иргэд зэрэг 800 гаруй хүүхэд залуус үзэж сонирхлоо. Их хотын иргэд, хүүхэд, залуусыг чөлөөт цагаа цэвэр агаарт зөв боловсон өнгөрөөх нөхцөл бололцоогоор хангах, эрүүл агаарт идэвхитэй хөдөлгөөнийг дэмжин унадаг дугуй, морь унах, үндэсний сур харвах, тоглоом, наадгайгаар үйлчлэх зорилготой манай хөтөлбөр Морин тойруулга, Үндэсний сурын талбай, гудамжны сагсан бөмбөгийн талбай тохижуулан үйл ажиллагаагаа илүү өргөжүүлсээр байна. Нээлтийн үеэр НЗДТГ-ын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа, МДХ-ны ерөнхийлөгч Ж.Батзандан, Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын дарга П.Цогтбаатар, МҮСХ-ны тэргүүн Д.Хүрэлбаатар үг хэллээ.

Хөтөлбөр 2015 оны 5 дугаар сарын 16-ний Бямба гарагаас 2015 оны 9 дүгээр сарын 19-ны Бямба гарагийг дуустал нийт 4 сарын туршид долоо хоногийн Бямба, Ням гарагуудад үргэлжилнэ.

Нийтийн тээврийн үйлчилгээ:

Бид Нийслэлийн иргэд, хүүхэд залуусыг хөтөлбөрт идэвхитэй оролцуулах үүднээс долоо хоног бүрийн Бямба, Ням гарагуудад УБ хотоос Хүй долоон худаг хүртэл нийтийн тээврийн унаа явуулахаар бэлтгээд байна. Автобусны маршрутын хувьд: Долоо хоног бүрийн Бямба, Ням гарагуудад өглөө 11:00, 13:00 цагуудаас:

Ялалтын талбай--- Саппоро--- 5 шар--- Хүй долоон худаг маршрутаар очно.

Долоо хоног бүрийн Бямба, Ням гарагуудад орой 17:00, 18:30 цагуудаас:

Хүй долоон худаг--- 5 шар--- Саппоро—Ялалтын талбай маршрутаар буцаж ирнэ. Хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр тогтмолоор сурталчилж, байгууллага, анги хамт олноороо амралтын өдрөө манай хөтөлбөртэй нэгдэн өнгөрүүлэхийг хүссэн бүх саналыг нээлттэйгээр хүлээн авч хамтран ажиллана.

Хамтрагч байгууллагууд:

Энэ жил манай хөтөлбөрт шинээр Монголын Үндэсний Сурын Холбоо ТББ сонирхогчдод зориулсан үндэсний сурын талбай тохижуулан, Монголын Морин Спорт Уяачдын Үндэсний Холбоо ТББ морин тойруулга тохижуулан гадаад, дотоодын аялал жуулчдад зориулан морь унуулах цэг гарган, “Мон- Алтон” ХХК солонгосын чанартай унадаг дугуйг иргэдэд зориулалтын зам талбайд унах боломж бололцоог бүрдүүлэн дугуйн түрээсийн тоог нэмэгдүүлэн бидэнтэй нэгдэн, бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж байна. Мөн 2014 оны анхны хөтөлбөрт хамтран ажиллаж байсан НЗДТГ, Найсраг Улаанбаатар хөтөлбөр, МДХ, МЗХ, ММЭкстрем Холбоо, “Аттила байк” ХХК болон бусад дугуйн клуб, дэлгүүрүүд, худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны газрууд, түрээсийн үйлчилгээтэй унадаг дугуй, тоглоомын газрууд нэгдэн Хүй долоон худагт амарч зугаалахаар ирсэн иргэдийн тав тухыг ханган ажиллахыг зорьж байна.

Тохижилт:

Хөтөлбөр хэрэгжих хугацааны туршид амралтын өдрүүдэд морин тойруулга, морь түрээсээр унуулах үйлчилгээний цэг, сонирхогчдод зориулсан үндэсний сур харвах үйлчилгээний цэг, дугуйн түрээсийн цэг, дугуйн зориулалтын зам, аяллын маршрут, төрөл бүрийн унадаг дугуй болон дугуйн дагалдах хэрэгслийн худалдаа, дугуй засварын үйлчилгээ, X-tream спортын талбай, гудамжны сагсан бөмбөгийн талбай, элсний волейболийн талбай, хүүхдийн хөгжөөнт тоглоомын мини парк, ролк түрээсийн үйлчилгээ, морин аяллын цэг, халуун хоол, цай, ундаа зэрэг бэлэн хүнсний бүтээгдэхүүн худалдаалах цэг, мэдээллийн цэг, зохион байгуулалтын алба, хамгаалалтын алба, байнгын сахиул ажиллана.

Чөлөөт аялал, амралт, зугаалгын өдөрлөг: 2015 оны 5-р сарын 16-ны Бямба гарагаас эхлэн 2015 оны 9-р сарын 19-ны Бямба гарагийг дуустал долоо хоног бүрийн Бямба, Ням гарагуудад үргэлжилнэ.

Хаалтын өдөрлөг: 2015-09-19-ний Бямба гарагт хөтөлбөрийн нэрэмжит дугуй, сур, сагсны тэмцээн сонирхогчдын дунд зохион байгуулна.

Хөтөлбөрийн танилцуулгын талаарх болон бусад тэмцээн уралдааны талаарх мэдээллийг www.ulaanbaatar.mn, www.mnts.ub.gov.mn вэб сайт болон [https://www.facebook.com/монгол наадам цогцолбор](https://www.facebook.com/монгол-наадам-цогцолбор) цахим хуудсаар авна уу.

